

Гантулга овогтой Аззаяа
ШУТИС-ҮТДСургууль, II-ркурсийн оюутан

“Авлига бол гарц биш”

Энэхүү эрдэм шинжилгээний материалыг бэлдэх явцдаа авилгалын талаарх судалгаа шинжилгээ, ном сурах бичиг, түүнтэй холбоотой хууль тийм ч бага биш байдгийг олж мэдсэн. Гэсэн хэдий ч яагаад манай иргэдийн дунд авилгал ингэж их газар авсан хийгээд түүний талаарх мэдлэг тийм хомс байгааг үнэндээ гайхаж байлаа. Эцсийн эцэст бид ярьж хэлэхээс биш амьдрал дээр ажил хэрэг болгож байгаа явдал үнэндээ хомс юм байна. Мөн эдгээр судалгаа шинжилгээний дийлэнх нь авилгыг хэн авч өгч байна, хаана хэдэн хувьтай байна вэ гэдгийг судлахаас биш хэрхэн яаж үүссэн учир шалтгаан, түүнээс хэрхэн сэргийлэх вэ гэдгийг үнэндээ авч үздэггүй бололтой. Тиймдээ ч би өөрийнхөө эрдэм шинжилгээний материалыг энэ тал руу хандуулахыг зорьлоо.

2000 онд дөнгөж 50 хүрэхгүй хувьд тооцогдож байсан авилгал саяхны нэгэн судалгаагаар бүр 96%-д хүрсэн байна. Тэгвэл авилгалын асуудал нь төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудтай холбогон гардаг онцлогтой. Учир нь хувийн хэвшлийн субъект нь хамгийн оновчтой хувилбарыг сонгох туйлын эрмэлзэлтэй байдаг тул авилга авах боломж бараг үгүй. Эмнэлэг, сургууль гээд бид бүхний өдөр тутам ханддаг төрийн хийгээд, төрийн бус байгууллагуудаас ахуулаад төрийн удирдах дээд байгууллага бүгд авилгад автагдсан нь олон арван судалгаанаас харагдаж байна. Гэхдээ авилгын талаарх ойлголт, иргэдийн хувьд дэндүү өрөөсгөл юм. Монголын авилгачдын жагсаалтыг цагдаа, эмч, багш, газрын албаны ажилтан нар үргэлж тэргүүлж байдаг. Тэгвэл эмч нарын хувьд ярья л даа. Амьдралынхаа бараг тэн хагасыг хүний эрүүл мэндийг хамгаалах талаар судлан өнгөрөөсөн хэрнээ авч байгаа цалин нь гайгүйхэн байгууллагын муухан цэвэрлэгчийн дайнд хүрдэггүй тэдний хувьд ганц хайрцаг шоколад, чихэр авсаныхаа төлөө авилгалын үүр болсон газар гэж тойдорхойлогдох нь эмгэнэлтэй. Тэгээд ч иргэд өөрсдөө чанар муутай эмнэлгийн үйлчилгээнээс залхан, бусдаас арай дээгүүр үйлчилгээ авахын тулд эмч сувилагчдыг хахуульдан, тэднийг хүний гар харахад хүргэсэн шүү дээ. Дөнгөж сургуулиа төгсөөд, шинэ албандаа орж байгаа эмч сувилагч авилгалын талаар ямар ч ойлголтгүй байж байгаад мэргэжил нэгт нөхдөө даган дууриасаар авилгал авагчдын тоог нэгээр нэмдэг. Гэхдээ тэдэнд буруу өгөх үнэндээ хэцүү. Засгийн газар бол нөөцийг хэрэгтэй газар нь зөв

зохистой хуваарилах үүрэгтэй газар. Тэгвэл улсын номер нэг анхаарал хандуулах ёстой газар бол эрүүл мэндийн салбар байдаг. Тэгвэл тэдний үүргээ биелүүлж чадаагүйн улмаас хүрэлцэхээ больсон өвчтөний ор, ямар ч шаардлага хангахаа больсон социализмын үеийн тоног төхөөрөмжөөр, амьдралын наад захын амь зуух хэрэгцээг ч хангахгүй цалин зэрэг нь авилгалыг дэмжигч хүчин зүйл болж өгдөг. Гэлээ ч үүнийг авилгын тоонд авч үзэхгүй бол энэ нь хүмүүсийг дараа дараагийн шатны авилгал өгч сургахад нөлөөлдөг юм. Энэ нь авилгал монгол оронд нүүрлэх болсны зөвхөн нэг шалтгаан төдийгүй энэ бүхэнд төрийн удирдах дээд байгууллага болох хууль батлан гаргагчид мөн хэрэгжүүлэгч агентлаг болох засгийн газар шууд холбоотой болохыг ахин өгүүлье. Зөвхөн энэ л жишээгээр авилгал нь нийгэмд- эдийн засаг, улс төрийн, эрх зүйн, зан заншил ёс зүйн гээд олон хэлбэрээр илэрч байгааг бид харж болох нь. Тэгээд ч үүнээс авилга улс төр хоёр шууд хамааралтайг нотлох ба эдгээрийг “дээд түвшний” авилгал гэх бөгөөд, энд бугшсан авилгын асуудлыг хэрхэн таслан зогсоож нийтэд ил тод болгох вэ гэдэг нь хамгийн том асуулт юм. Улс орон бүхэлдээ ядуу байх тусам авлигын хэмжээ уг улсад төдийчинээ их дээгүүр байна. Авлигын түвшин хэдийчинээ өндөр байна далд эдийн засгийн түвшин төдийчинээ өндөр байна. Тэр нь ч ойлгомжтой. Таны олон арван хоног бүтээгээд чадахгүй байсныг ганцхан секундын дотор мөнгө атгуулж байгаад амжуулаад гарвал танд ямар байх вэ? Танд цаашид үнэнч шударгаар хөдөлмөрлөх сэтгэл төрөх үү? Энэ бодол хүн болгоны толгойд нэвт шингэх юм бол монголд үнэнч шударгаар ажил хийх хүн олдох болов уу! Энэ байдлаараа авилгалын тоо хэмжээ 100%-д хүрвэл би л лав хувьдаа гайхахгүй. Тэгээд л улс орны хөгжил зогсонги байдалд орж, худал хуурмаг байдал нийгэмд ноёлож, баян ядуугийн туйл дээд цэгтээ хүрнэ.

АНУ-ын улс төр судлаач Д.Бейли, Ж.Най, К.Фридрих нарын судалгаанд авилгалыг “эрх мэдлийг хувийн зорилгодоо ашиглах”, “хувийн эрх ашгаа хангахын тулд нийтийн эрх ашгийг үл тоомсорлох”, “нийгмийн эрх ашгийг худалдсанаар хувийн эх ашгаа хангах” гэх мэтээр тодорхойлсон байдаг. Эдгээр тодорхойлолтонд байгаа ерөнхий санаа бол авилгалын үндсэн шинж нь нийтийн эрх ашгийг хохироох замаар хувийн эрх ашгийг хангадаг гэсэн утга байгаа юм. Авилгалыг өнгөц харахад нэг хүн нөгөөдөө мөнгө юм уу эд зүйл өгч байгаа эдийн засгийн

хүрээнд гардаг материаллаг үзэгдэл мэт авч мөн чанараараа ёс суртахууны ялзрал юм. Оксфордын тольд тодорхойлсноор энэ үгний ёс суртахууны, хуулийн, физикийн, биологийн гэсэн дөрвөн утга байдаг. Эдгээрээс нэгдүгээр утга буюу ёс суртахууны ялзрал нь бидний ярьж байгаа утга мөн. Материаллаг зүйлээр илрэн гарч байгаа ёс суртахууны уналтыг авилгал гэж болно. Авилгач хүн бол юуны түрүүн ёс суртахууны, дараа нь хуулийн гэмт хэрэгтэн байдаг.

Авилгал гэдэг энэ үзэгдэл голчлон эрх мэдэлтний хүрээнд гарах аж. Тэгвэл нийгэмд ажил хөдөлмөр эрхэлж байгаа ямар ч хүнд их, бага ямар нэг хэмжээний эрх мэдэл бий. Ямар ажил хийж байна, тэр хэмжээндээ эрх мэдэлтэй байна. Энэ эрх мэдлээ та хувийн зорилгоор ашиглаад эхлэх юм бол авилгал руу ойртож байна гэсэн үг.

Мөн авилгал нь хөшигний цаана явагддаг, авсан, өгсний аль аль нь түүнийгээ нуухыг зорьдог зэргээс үүдэн нуугдмал шинжтэй байдаг. Тиймээс ч Монгол улс үндсэн хуулиндаа “Авилгалын эсрэг хууль”-ийг 1996 оны 4-р сарын 5нд, 3 бүлэг 18 зүйлтэйгээр баталсан бөгөөд уг хуулинд зааснаар “Авилга гэж хээл хахууль авах, хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал, боломжоо ашиглах, ийнхүү ашиглуулахаар түүнд шан харамж буюу хөнгөлөлт, давуу талыг хувь хүн, хуулийн этгээдээс олгох явдлыг ойлгоно” хэмээн тодорхойлсон байдаг. Социализмаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнуудад авилгалын төвөгтэй, ээдрээтэй байдал бий болдогийг эдийн засагчид батлан хэлсэн байдаг. Тиймээс энэ л үед бид авилга хэмээх ойлголттой гүн гүнзгий холбогдсон гэж хэлэхэд болно.

Мөн авилгал бидэнтэй үргэлж хамт байсаар ирсэн гэхэд хэлсдэхгүй, үүнийг “Нууц товчоо”-нд өгүүлснээр, Тэмүүжин Тоорил ванд очиж “булган дах өгөх” бөгөөд хариуд нь Тоорил ван “бутарсан улсыг цуглуулж” өгдөг. Үнэхээр Тэмүүжин өөрийн ажлыг бүтээхийн тулд Тоорил ванд булган дах өгч, Тоорил ван ч мөн тэр шалтгаанаар төр-улсын цэргийг хөдөлгөсөн бол хахуульдагч нь Чингис хаан, хахууль авагч нь Тоорил ван болж таарч байгаа юм.

Тэр үеийн монголчуудын авилгач зангийн тухай Монголыг анх дэлхий ертөнцөд нээсэн хүмүүс болох Плано Карпини, Гильом де Рубрук нарын аян замын тэмдэглэлд ч дурьдсан байдаг. Монголчууд жирийн нэг иргэнээсээ эхлээд

мяндагтан зэрэгтэнээ хүртэл гадны элч төлөөлөгч, худалдаачдыг өөрийн нутаг дэвсгэрээр өнгөрүүлэх, эсвэл дээд зиндааны хүнтэй уулзуулахад зуучлах зэргээр хийх ёстой зүйлийг хийснийхээ төлөө байнга хахууль авдаг байжээ.

Түүхийн дараагийн нэгэн үе болох Монгол улс харийн дарангуйлал дор байсан 300 орчим жилд авилгал ид цэцэглэсэн. Янз бүрийн цол хэргэм, албан тушаалыг ёс мэт авилгалаар олж авдаг байж. Өөрсдөд нь эзлэгдсэн нэгэн буурай улс орны дотоодод нь явагдаж буй ялзрал, хямрал манж нарт төдий хамааралтай биш байсан учраас хээл хахуульд хориг тавих нь бүү хэл улам бүр өөгшүүлэх хандлага ихэд байсан.

Социализмын үед авилгал ихээхэн далд хэлбэртэй болж, тэр хэрээрээ ч авилгалын жинхэнэ хэлбэр рүү орсон. Авилгал энэ үед нэрээ өөрчилж бэлэг хэмээн нэрлэгдэх болов. Бэлэг, авилгал хоёрын зааг ялгааг гаргахад үнэхээр хүнд байдаг. Үнэхээр чи сэтгэл харамгүй бэлэглэж байгаа юм бол үнэ бүхий зүйл өгөх ёстой. Гэхдээ бэлэг чинь үнэтэй байх хэрээр та нөгөө хүнээ эрхэндээ оруулж буйгаа бас мэдэрнэ. Нэгэнт үнэтэй бэлэг өгсөн хүний хувьд тэр эрх мэдэл бүхий хүн дээр орж, юм гуйх эрхтэй болоод авна. Авилгалыг хэтэрхий илэн далангүй, улайн цайм өгөлцөж авдаг болсон өнөө үед ч бэлэг гэсэн нэрээр түүнийгээ далдлах явдал харагдсаар байна.

Зөвхөн манай оронд ч гэлгүй авилга бол аль ч орны хувьд шүдний өвчин гэхэд болно. Ардчилалыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурлын баримт бичигт авилгалтай тэмцэх арга хэмжээнүүдэд дараахь зүйлүүдийг оруулсан байна. Үүнд:

- Улсын албан тушаалтнуудын зан үйлийн хатуу чанд дүрэм гаргах
- Хээл хахуулиар олсон хөрөнгө буюу орлогыг угаах боломжийг үгүй хийх
- Сайн засаглалын практик болон цэвэр ариун байдлын нааштай эх суурийг нэвтрүүлэх
- Улсын болон бизнесийн байгууллагуудын авилгалд автах практиктай тэмцэх үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллагуудтай ажиллах
- Авилга хээл хахуульд өртсөн бүхнийг илрүүлж, мөрдөн шалгаж шийтгэх
- Улсын албан хаагчдад хахууль, шан харамж өгөхийг гэмт хэрэгт тооцох

- Төрийн дээгүүр албан тушаалтнууд өөрсдийн хувийн хөрөнгө болон өр төлбөрийн талаар зохих байгууллагад мэдээ гаргаж өгч байх
- Хээл хахууль өгч авалцах явдлыг түмний соргог хараанаас мултрах аргагүй болгохын тулд улсын байгууллага дээр нарийн хяналт судалгаа явуулах, бүтцийн болон дүрэм журмын шинэчлэлт хийх асуудлыг нээлттэй хэлэлцэх үйл журмыг халах болон хялбарчлах
- Гадаад орны төрийн албан хаагчдын хахуульдах үйлдэлд дотоодод мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагчид болон үндэсний байгууллагуудын хууль эрх зүйн хэм хэмжээтэй хослуулан эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болох
- Омбудсмэн буюу авилгалтай тэмцэх комиссуудын хүчийг ашиглан хяналт шалгалтын болон албадлагын арга хэмжээ авах зэрэг болно.

Харин ард иргэдээс авсан санал асуулгын дүнд авилгалыг хориглогч хүчин зүйлс нь:

- Авилгал, хээл хахууль авсан, өгсөн тохиолдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ил тод, чөлөөтэй хэвлэн нийтэлж, олон түмний сонорт хүргэж байх;
- Авилгал, хээл хахууль гарах нөхцөл байдал, хор уршгийн талаар бүх шатны сургуулиудад хичээл оруулж, хүүхэд, залуучуудад авилгалыг жигших ухамсар эртнээс төлөвшүүлэх
- Авилгал, хээл хахуультай тэмцэх талаар иргэдийн санал бодлыг тусгасан төсөл, санал санаачлагыг урамшуулах хөдөлгөөнийг өрнүүлэх.
- Юуны өмнө авилгалтай тэмцэх хууль нь хатуу чанга байхаасаа илүү хэрэгжих бололцоотой байх ёстой гэж бодогддог. Учир нь хэт чанга хууль авилгалыг улам бүр далд, нууц хэлбэртэй болоход нөлөөлж болно. Иймд харьцангуй “зөөлөн заалтуудыг” чанд биелүүлэх замаар хуулийн заалтуудаа аажмаар чангаруулах хэрэгтэй байж болох юм. Гэхдээ манай одоогийн мөрдөж байгаа хуулийг чанга гэж үзэх нөхцөл огт байхгүй. Иймд шинэчлэн боловсруулж байгаа хуулийн төслийн хэрэгжих нөхцөл, бололцоон дээр онцгой анхаарах ёстой.

- Авилгалын хуулийн талаар авилгалд өртөмтгий салбарт ажилладаг эрх мэдэл бүхий хүмүүст сургалт, семинар зохион байгуулж, шалгалт аван, уг шалгалтын дүнг ажилдаа тэнцэх үү, үгүй юу гэсэн нэг гол шалгуур болгох.
- Хувийн хэвшил дэх авилгалын талаар илүү тодорхой заалтуудыг оруулж өгөх.
- Авилгалд өртөмтгий салбаруудын эрх мэдэлтнүүд орлогоосоо илүү баян, тансаг байдалтай (нүдэнд илэрхийгээр) амьдарч байгаа тохиолдолд хууль, хяналтын байгууллагаас шалгалт оруулж байх эрхийг хуульчилж өгөх.
- 1996 оны хуулинд, хуулийн зохицуулалтанд хамаарах этгээдийг хэт явцуу тодорхойлсон. Жирийн иргэдийн хүрээнд ч зохих хэмжээний авилгал байдаг тул энэ заалтанд хамрагдагсдыг хүрээг өргөтгөх.
- Уг хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага хэт хөнгөн (20000-30000, 30000-40000 төгрөгөөр торгох гэх мэт) байгааг чангатгах. Цаазаар авах нь юу юм, харин хорих хүртэл арга хэмжээг өргөнөөр авах.

Үүнээс би авилгалыг таслан зогсоож чадах зүйл бол 1/эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлж, авилга авч бас өгч байгаа хүмүүсийг нийгэмд нээлттэй таниулж жигшин зэвүүцэх сэтгэлийг бий болгох, 2/ авилгалын талаарх хуулийн хэрэгжилтийг сайжруулах, 3/ хариуцлагын тогтолцоог илүү чангатгах 4/ төрийн давж барашгүй нүсэр аппарат, хүнд суртлыг багасгах хэмээн бодож байлаа (төрийн байгууллагуудын зохион байгуулалтын буруугаас болж авилгал гарах тохиолдол ч багагүй байдаг. Энэ бол хүнд суртлын тухай ярьж байгаа хэрэг. Зарим ажил хэргийн хүмүүс ажил хөөцөлдөх үедээ яам, тамгын газар болон бусад эрх мэдэл бүхий газруудад илүү шат дамжлага байгааг мэдэрдэг байна. Ийм нөхцөлд тэд замаа “товчлох” үүднээс гол шийдвэр гаргагчид “хууль бус замаар” ханддаг. Энэ нь бас л авилгал гарах нэг шалтгаан болдог). Гэтэл авилгалын талаар улам дэлгэрэнгүй судлах тусам миний бодол өрөөсгөл болохыг би ойлгосон юм. Үндсэн гол зорилго бол хээл хахуулийг практик ажил болгодог гол гол түлхээсийг буруулах явдал чухал, харин авлигачдыг илрүүлэх, шийтгэх тогтолцоог улам хатуу болгох нь гол зорилго биш юм байна. Хатуу ширүүн байх нь бас хэрэгтэй ч гэсэн авлигыг өөгшүүлдэг тогтолцооны нөхцлийг хязгаарлахгүй бол алсдаа энэ бүхэн төдийлөн их ач холбогдолтой байж чадахгүй. Хэрэв авилгалд түлхдэг хүчин зүйл

хэвээрээ үлдвээс “авлигаар хамуурсан түшмэдийн” нэг хэсгийг дарж устгалаа гэхэд авлигач түшмэл, хахууль атгуулагчдын цоо шинэ тоо толгой өөр нэг газар өндийн гарч улам “аюултай”, улам “боловсронгүй” болдог байна. Улам боловсронгуй болж буй нь нэгэн жишээ бол П. Мауро гуайн “Авилгалд их идэгдсэн орнууд боловсролд зориулах зардлаа багасган хүмүүнлэгийн хүрээнд оруулах хөрөнгөө бууруулахыг эрмэлздэг гэдгийг нотолсрн явдал юм”. Яагаад гэвэл хөрөнгө их шингээдэг бусад салбарыг боловсролын салбарт хахуульдах боломж ихээхэн бага байдагтай холбоотой аж.

Тиймээс ч авилга үүсэх нэг шалтгаан нь улсын болон хувийн байгууллагууд муу ажилладагт оршино. Урагшгүй засгийн газрууд гадаадын тусламжийг зөв ашиглах чадваргүй. Бага орлоготой эсхүл эдийн засгийн өсөлтийн доогуур хурдацтай орнууд ямагт бэрхшээлтэй учирдаг, яагаад гэвэл тэдгээр нь өөрийнхөө хүний болон материаллаг нөөцийг үр өгөөжтэй ашиглах чадваргүй тиймээс төрийн шинэтгэл хийх нь зөв юм гэсэн гол ойлголт гарч ирнэ. Шинэтгэл нь авлигыг бүрэн үндсээр нь тастан арилгахдаа биш, харин төрийн машины үр ашигтай, шудрага, хуулиа сахидаг байдлыг далайцтай төгөлдөржүүлэх гол зорилготой байх ёстой. Авлигыг хоггүй арилгаж устгах боломжгүй ч түүнийг хазаарлан зогсоох, түүний учруулж буй хор уршигийг багасгахад чиглэсэн арга хэмжээ авах боломжтой. Мөн түүнчлэн үндсэн хуулийн хүрээний хэд хэдэн бүтцэд ч, зах зээл төр засгийн хоорондох суурь том харилцаанд ч өөрчлөлт хийх шаардлага үүсч болно. Мөн шинэтгэлийг өөрийн оронд амжилттай хийж гүйцэтгэсэн улс орны түүхийг судлах буюу “практикийн хамгийн шилдэг жишээ баримт”-ыг харгалзан үзэх нь нэн чухал юм. Гэхдээ энэ нь шууд хуулбарлан гэсэн үг биш бөгөөд өөрийн орны тодорхой нөхцөлд таарахуйц шинэтгэлийн багцыг сонгон судлахыг хэлнэ. Жишээ нь улс орнууд янз бүрийн арга, замаар авилгалтай тэмцэж байна. БНХАУ-д цаазаар авах ялыг хүртэл хэрэглэснийг бид хэвлэл, мэдээллийн хэрэгслээс мэдэж байгаа билээ. Хонконгд 1974 онд авилгалын эсрэг маш хүчтэй хууль баталж, авилгалын эсрэг төрийн албанаас гадуурх байгууллага болох Авилгалын эсрэг тэмцэх бие даасан Хороог байгуулсан нь их үр дүнгээ өгч байжээ.

Авилгалыг судалж, түүнтэй тэмцдэг олон улсын байгууллагаас (Transparency International) гаргасан нэгэн судалгаагаар, сүүлийн 30 – 40 жилд

БНСУ, Африкийн Гана гэсэн хоёр улс бусад улс орон, олон улсын байгууллагуудаас ижил хэмжээний зээл тусламж авчээ. Гэтэл одоо энэ хоёр улсын хөгжлийн түвшин эрс өөр болж, нэг нь (БНСУ) дэлхийд хөгжлөөрөө гайхагдаж байхад нөгөө нь (Гана) урьдын дорой буурай орон хэвээр үлджээ. Энэ бол авилгал улс орны хөгжилд ямар сөрөг нөлөөтэйг харуулах тод жишээнүүдийн нэг юм. Авилгалд өртсөн улсад гадны зээл, тусламж төдийгүй дотоодын татвар төлөгчдийн улсдаа шударгаар төлсөн мөнгө хүртэл элсэнд шингэсэн ус мэт алга болдог байхыг бид бэлхнээ харж болхнээ.

Хахууль төрийн түшмэдийн амин орлогыг арвижуулж байхад хууль ёсны төлбөрийн мөнгө улсын төсөвт орж байдаг. Энэ бол чухал, ашиг сонирхлоо бодсон хэдхэн хүний гарт эрх мэдэл төвлөрч дийлэнх олон нь үгэйгүй ядуу болно гэсэн үг. Үүнээс төрийн түшмэд авилга үүсгэх нэг шалтгаан болж байгааг харж болно. Тэгвэл үүнийг Адам Смитийн “үл үзэгдэгч гар”-ын онолоор зохицуулж болох юм. Хүмүүсийн ашиг хонжоо олох гэсэн аж ахуйн үйл ажиллагаа нь тэднээс үл шалтгаалах бодит хуулиар зохицуулагдаж байдаг нь “үл үзэгдэгч гар”-ын онол бөгөөд эдийн засгийг аль болох чөлөөтэй байлгах, зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, чөлөөт үнийн механизмд ямар нэгэн хязгаарлалтыг засаг төрийн зүгээс хийхгүй байх ёстой, төр нь эдийн засгийн амьдралд зөвхөн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих л үүрэгтэй гээд хэрвээ ингэж чадвал эдийн засгийг жам ёсных нь журманд оруулж үр өгөөжтэй болгон гэдгийг анхааруулж байв. Энэ нь зөвхөн эдийн засгийн хувьд ч биш бусад салбарын хувьд төрийн оролцоо бага байх нь улс төрчдийн өөрийн эрх мэдлийг ашиглан хээл хахуулийг даамжруулах асуудлыг багасгах боловч энэ нь хөгжлийн түвшин доогуур оронд тэр бүүр хэрэгжихэд бэрх юм. Үүнийг сонгодог эдийн засаг гэх бөгөөд өндөр хөгжилтэй оронд л хөгжиж болохуйц тул тэнд л авилгалын түвшин доогуур байх нь ойлгомжтой.

Тиймээс авилгалын тархац, хор хөнөөлөөр нь авч үзвэл энэ асуудал манай улсын хувьд зөвхөн хуулийн байгууллагын хүрээнд шийдэгдэх асуудал нэгэнт биш болж, энэ талаар улс, эх орноо гэсэн иргэн хүн бүр санаа зовох, санаа зовохоор үл барам өөр өөрсдийн хэмжээнд тэмцэл явуулах цаг болжээ.

Ашигласан ном зохиол:

- “Авилгалыг Дэмжигч болон Хориглогч Хүчин Зүйлс” МУИС, Орчин үеийн улс төрийн судалгааны төв
- “АВИЛГАЛ: Мөнхийн үзэгдэл биш” МННХ, Соросын сан, Зориг сан
- “Авилга, төр хоёр” Сьюзан Роуз-Аккерман
- Авлигыг хэмжихүй: Хэрэглэгчийн гарын авлага